

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2021.06.20

Өв.Өлзийт сум

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ /хүчингүй болсон хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Байгаль хамгаалал аялал жуулчлалын газар 1					
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
1	3	<p>Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018.05.30 №46 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах, үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачлагыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагад чиглэл болгосугай</p>	<p>Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд албан байгууллагуудын ажилчдаас монгол бичгийн шалгалт авч түвшин тогтоож гурав ангилсан байгаа. Анхан шат, дунд шат, дээд шат гэж ангилан танхимаар мэргэжлийн багшаар хичээл заалган сурч байгаа. Хоёр албан байгууллага хаягаа монгол бичгээр хаягалсан.</p>		

1.	1.	Мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2010.04.14 Дугаар 63 1.Жил бүрийн 5,10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласан.	Бүх нийтээр мод тарих хөдөлгөөн өрнүүлэх тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Ойн тухай хуулийн 31.1 дахь заалтын дагуу 2018 оны бүх нийтээр мод тарих үндэсний өдөр эхэлж байгаатай холбогдуулж шинээр тарьсан мод бутыг сумын ногоон байгууламжийн мэдээллийн санд бүртгэж тэмдэгжүүлэх ажлыг хэрэгжүүлж ажилласан. 5 дугаар сард мод тарих ажлыг зохион байгуулав. Хэрэгжилт 100%		
	2	2.Мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалах, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэн сурталчилж ажиллахыг Монгол улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хандивлагч нарт уриалсан.	Сумын албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс тарих мод, бутны хэрэгцээ, захиалгыг нэгтгэж орон нутагтаа дасан зохицож ургах боломжтой, стандартын шаардлага хангасан тарьц, суулгацыг аж ахуйн нэгжүүдээс захиалга авч нийлүүлж байдаг. Энэ жилийн хувьд ковид-19 гарсантай холбогдуулж тарьц суулгацны нийлүүлэлт муу байсан. Аж ахуйн нэгж, иргэд нийт 135 чацарганы мод тарсан. Цэцэрлэгт хүрээлэнгийн хогийг цэвэрлэж борог өвсийг хадаж модгүй хэсгийг шатааж бордлоо хавар газар гэсэх үеэр усалгаа арчилгаа хийгдсэн, намар цас эрт орсон учраас цэнэг усалгаа хийгдээгүй. Хэрэгжилт 70%		
Дундаж үнэлгээ:					
1.г МУ шатар сайд:					
45	2	Журам батлах тухай	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх		

		<p>/Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам/</p> <p>2021.02.21 Дугаар 45</p> <p>2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг олон нийтэд сурталчилан таниулж, хэрэгжүүлэхийг холбогдох бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>талаар сургалт сурталчилгааг цахим хэлбэрээр зохион байгуулж өдөр бүр ЭМЯ болон ЭМГ-аас гаргасан мэдээ мэдээллүүдийг ЭМТ-ийн болон сумын нэгдсэн группт өдөр тутам байршуулж иргэдэд урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч ажиллаж байна.</p>		
78	1	<p>Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай</p> <p>2021.03.25 Дугаар 78</p> <p>1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал сунгасугай.</p>	<p>Ковид-19 үийн цар тахлын хариу арга хэмжээний бэлэн байдлыг 90% хангасан байна</p> <p>Цар тахлын үеийн эмч эмнэлгийн мэргэжилтний нөөц ажиллах чиг үүрэг тодорхойлж баталгаажуулсан. Нэг удаагийн хамгаалах хэрэгслэлийг тухай бүрт хангагдаж ЗДТГ -1250,0 төгрөгийн хандив , иргэд- 800,0,4 хонь хандивласан байна.</p> <p>Тусгаарлан эмчлэх 12 ор бүхий байртай.</p> <p>Нийт 2021 оны 6 сараас эхлэсэн цар тахлын үед нийт батлагдсан – 186, эмнэлэгт –120 гэрээр- 67 үүнээс тээвэрлэсэн- БОЭТ -5 Улаанбаатарт-1 хөнгөн-180 хүндэвтэр-5 хүнд-1 маш хүнд-1 байна. Дархлаажуулалтанд нийт 1722 иргэн 3 тунд хамрагдахаас</p> <p>1-р тунд 1722</p> <p>2-р тунд 1827</p> <p>3-р тунд 571 иргэн хамрагдсан байна.Цар тахлын</p>		

			<p>үеийн бэлэн байдлыг ханган тусгаарлах байр болон ажиглах байрны бэлэн байдлыг ханган тохижуулсан. Спортын заалыг тусгаарлан эмчлэх, дунд байрыг тусгаарлах байр болгон тохижуулан ажилласан. Одоогийн байдлаар 1 иргэн Ковид-19 өвчлөлөөр эмчлэгдэн гарсан. Эмчлэгдэн эдгэрсэн иргэдийн эмийн болон хоол хүнсний зардлыг Нийгмийн даатгалын сангаас зардлыг гарган ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт100%</p>		
91	1	<p>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай</p> <p>2021.04.08 Дугаар 91</p> <p>1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.</p>	<p>Хорио цээрийн дэглэмийн үед дэлгүүрийн худалдагч нарт хүргэлтээр ажиллах, мөн халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн мөрдөж ажиллах талаар сургалт хийж бүртгэл хяналтын системийг бүртгэж ажиллаж байна.</p>		
104	1	<p>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай</p>	<p>2021 онд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын нөөц болон ЭМГ-аас Түргэвчилсэн тест, нэг удаагийн хувцас хэрэглэгдэхүүн, эм тарианы нөөцийг бүрдүүлж ажилласан.Нөөцийн хомсдол үүсээгүй.</p>		

		<p>2021.04.23 Дугаар 104</p> <p>1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 05 дугаар сарын 8-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.</p>	<p>2021 онд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын нөөц болон ЭМГ-аас Түргэвчилсэн тест, нэг удаагийн хувцас хэрэглэгдэхүүн, эм тарианы нөөцийг бүрдүүлж ажилласан.Нөөцийн хомсдол үүсээгүй. Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээний бэлэн байдлыг 90% хангасан. Цар тахлын үеийн эмч эмнэлгийн мэргэжилтний нөөц, ажиллах чиг үүргийг тодорхойлж баталгаажуулсан. Нэг удаагийн хамгаалах хэрэгслийг тухай бүрт хангаж Засаг даргын Тамгын газар 1250,0 мянган төгрөгийн, иргэд 350,0 мянган төгрөг, оношлуур 850ш 5980,0 мянган төгрөгөөр бэлтгэсэн байна. нийт төгрөгийн хэрэгсэл бэлтгэн тусгаарлан ажиглах байр 18 ор бүхий байрыг бэлтгэсэн. Тусгаарлан эмчлэх 12 ор бүхий байртай, багаж хэрэгсэл, хүчилтөрөгчийн 2 баллон, машины хүчилтөрөгч 1, вирусын 3 төрлийн эм, бусад эм эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангасан байна.</p>		
183	2	<p>Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2021.07.02 Дугаар 183</p> <p>2. Аймаг, сумдын баяр наадам, хурдан морины уралдаан, уул, овооны тахилга, тэмдэглэлт ой зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй ... бүх шатны Засаг дарга нарт үүрэг</p>	<p>Засгийн газар өмнөх хуралдаанаараа Үндэсний их баяр наадмыг цахимаар шийдвэрлэсэн. Гэхдээ ЭМЯ болон бусад байгууллагын дүгнэлтээр Үндэсний их баяр наадмыг хойшлуулснаар 12 мянган хүн бөөгнөрч 3000 мянган хүн халдвар авах эрсдэлтэй гэсэн дүгнэлт гаргасан юм. Энэ дагуу Үндэсний их баяр наадмыг нэг жилээр хойшуулах шийдвэр гаргасан.</p> <p>Аймаг, сумдын наадмыг ч мөн нэг жилээр хойшлуулж байгаа бөгөөд үүнээс хэмнэсэн зардлыг эрүүл мэндийн салбарт зарцуулна. Харин энэ сарын 10-19-нд бүх</p>		

		болгосугай.	<p>нийтээр амрах шийдвэрийг хэвээр үлдээжээ. Тодруулбал, Үндэсний их баяр наадмаар тав хоног амардаг. Хуулийн хүрээнд Засгийн газраас энэ сарын 16-ны баасан гаргийн ажлын өдрийг 24-ний бямба гарагт шилжүүлж нийт 9 хоног амрахаар шийдвэрлээд байгаа юм.</p> <p>"Улсын Онцгой комисс нь цар тахлын тархалтыг хумих, бууруулах арга хэмжээ авах ард түмний шаардлагыг харгалзан үзэхийн зэрэгцээ Эрүүл мэндийн яам, эрдэмтэн судлаачдын дүгнэлтэд үндэслэн Үндэсний их баяр наадмыг хойшлуулах санал гаргасан. Мөн аймаг, сумдын баяр наадам, хурдан морины уралдаан, уул, овооны тахилга, тэмдэглэлт ой зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулаагүй. Ирэх жил Ардын хувьсгалын 101 жилийн ой, сум байгуулагдсаны 91 жилийн ойтойгоо хамтатган</p>		
	1	<p>Журам батлах тухай 2018.03.14 №67</p> <p>1. Гамшгийн эрсдлийн үнэлгээ хийх журмыг хавсралт ёсоор баталсугай.</p>	<p>Гамшгаас хамгаалах эрсдлийн үнэлгээг сумын онцгой комиссын жижүүр хийж дунд зэргийн эрсдэлтэй үнэлгээ гарсан. Улсын онцгой комиссын гаргасан заавар журмын дагуу үнэлэж засаг даргын захирамжын хавсралтаар баталсан тус суманд команд штабын сургалтыг 5 дугаар сард зохион байгууллахаар шийдсэн боловч цар тахалтай уялдуулан хойшлуулсан байна.</p> <p>Хэрэгжилт 70%</p>		
	1	<p>Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 2021.05.27 №154</p> <p>1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа,</p>	<p>Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд тогтмол гурван пост ажиллаж байна. Мөн оройны 21 цагаас өглөөний 09 цаг хүртэл шөнийн хөдөлгөөнт эргүүл явж байна. Хүн хоорондын зайгаа бариж амны хаалтаа тогтмол зүүж гараа ариутгаж байхыг хянан ажиллаж байна. Хүнсний дэлгүүр, шатахуун түгээх станцын цагийн хуваарийг 10 цагаас оройны 18 цаг хүртэл ажлуулж байна. Архи</p>		

		нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал сунгасугай.	согтууруулах ундаа худалдаалахыг түр хориглосон байна. Хэрэгжилт 70%		
Батлан хамгаалах яам 2					
41	1	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2021.02.17 Дугаар 41 1. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 6,350,895 байхаар тогтоосугай.	Цэргийн албыг мөнгөн төлбөрөөр орлуулан хаасан иргэн байхгүй		
220	2	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг батлах тухай 2021.07.28 Дугаар 220 2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2019-2021 онд 3-р багийн иргэн С.Гонгор, Ц.Ёндон нар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж дуусгасан. 2020-2022 онд 1-р багийн иргэн Намжилдорж, 4-р багийн иргэн Лүүжин нар, 2021-2023 онд 2-р багийн иргэн Г.Шаарав, 4-р багийн иргэн М.Пүрэвжамц, М.Гантөмөр нар дүйцүүлэх албыг хааж байна. Дүйцүүлэх алба хааж байгаа иргэд аймагт цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалтад 14 хоног, аймгийн бүтээн байгуулалтын ажилд 21 хоног, Тарны гүүрэн дээр Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлаар ажиллаж байгаа хүмүүстэй 14 хоног, Хархорин суманд 15 хоног тус тус ажилласан		

Хэсгийн дундаж 100%

Засгийн газрын хэрэг эрхлэх газар

1		<p>Журам батлах тухай 2020.12.16 №218</p> <p>1. “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.</p>	<p>Төрийн жинхэнэ албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулсан төлөвлөгөөнийхөө дагуу ажиллаж байна.</p> <p>Хагас жилийн байдлаар төрийн захиргааны албан хаагчид Монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 100 дугаар тушаалаар батлагдсан журмын 8 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ирүүлсэн байна.</p>		
.3	4.	<p>“ГУРВАН ТУЛГУУРТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО” БАТЛАХ ТУХАЙ 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдөр Дугаар 42</p> <p>2.“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2018-2020 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Гурван тулгуурт хөгжлийн хөгжлийн бодлогын суманд хамааралтай 55 заалтын биелэлтийг тооцож ажиллаж байна. 2018 оныг хариуцлагын жил болгон зарласантай холбогдуулан 13 зорилт Засгийн газрын сахилга хариуцлага дэг журмыг чангатгах тухай 2017 оны 1-р албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлэх 42 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Албан байгууллагын дарга, эрхлэгч нар, төрийн албан хаагч нарын үр дүнгийн гэрээнд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагаа, улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан зорилтыг тусган ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг сумын Засаг даргын үйл ажиллагааны Мөрийн хөтөлбөр, жил бүрийн сумын нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлэхдээ албан байгууллагын дарга эрхлэгч, албан хаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган биелэлтийг тооцож ажиллаж байна.</p>		

			Хэрэгжилт 70%		
	5.	3.“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д тусгасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, бодлогын хэрэгжилтийг уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийн явцыг нэгтгэн жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар тус тус даалгасугай.	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Монгол улсын Засгийн газрын 01 дүгээр албан даалгавар, Монгол Улсын Засгийн газрын 258 дугаар тогтоол, Төрийн албан хаагчийн манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай аймгийн засаг даргын 03 дугаар албан даалгаварыг мөрдөж хэрэгжилтийг тооцож төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Удирдах албан хаагч нар хөрөнгө орлогын мэдүүлгийг нэг гаргасан. Ажил хариуцсан албан хаагч нар өөрийн ажил төрөлтэй холбоотой хуулиудаар сургалт сурталчилгаа зохион байгуулан ажиллаж сумын Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хууль эрх зүйн төлөвлөгөөг боловсруулж батлуулан Хэрэгжилт 100%		
4.	6	БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр Дугаар 62 3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын	Сумын шуурхай штабын ерөнхий жижүүрээр Сумын засаг дарга Ё.Рэнцэндорж, Тамгын газрын дарга Л.Гантулга, хэсгийн төлөөлөгч Ц.Хад-Оргодол, бичиг хэргийн ажилтан М.Цэрэнханд нар ажилласан. Хариуцлагатай эргүүлээр Тамгын газрын дарга Л.Гантулга, хэсгийн төлөөлөгч Ц.Хад-Оргодол нар ажилласан, Энэ хугацаанд “Өвөрхангай Өлзийт” фейсбүүк группэд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил болон эргүүл, шалгалт хийж байгаа явцын тухай зураг, мэдээллийг цаг алдалгүй ард иргэдэд хүргэсэн. ЭМТ-ийн электрон самбараар сэрэмжлүүлэг, зөвлөмжийг байнга явуулж байна. Сумын Онцгой комиссоос дэлгүүр, аж ахуйн нэгж, байгууллагуудад улсын Онцгой		

		удирдлагад үүрэг болгосугай.	комиссоос гаргасан Уриалгыг хэвлэж мэдээллийн самбарт наасан. Эрүүл мэндийн төв болон албан байгууллага, аж ахуйн нэгж байгууллагууд 2 цаг тутам ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, эрүүл мэндийн төвд шинэ коронавирусын талаарх цаг үеийн мэдээлэл болон урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж зөвлөгөө өгөх утсыг ажиллуулсан. Гудамж талбайгаар явган зорчигч болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан Худалдаа, үйлчилгээний газрууд, дэлгүүр, үйл ажиллагааг түр хугацаагаар хаасан. Хэрэгжилт 100%		
5.	7.	ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Дугаар 33 2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн Ёс зүйн дүрмийг албан байгууллагын ажилтан албан хаагч нарт танилцуулан гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна. Төрийн албан хаагч нарын ёс зүйд анхааран ажиллаж хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил дутагдал гаргасан албан хаагч гараагүй байна. Хэрэгжилт 100%		
6.	8.	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2020 оны 11 дүгээр сарын 11 дугаар 178 4.	Хэрэгжилт 100%		
7	9	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Дугаар 382 2. Төрийн албаны тухай	Үйлчилгээний төрийн албан хаагч нарт төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тогтоол журмын дагуу олгож, ЗДТГ-ын газар тариалан, төрийн сангийн мэргэжилтэн нарт “туслах түшмэлийн” гутгаар зэрэг олгосон. Бүх албан		

		хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	байгууллагын үйлчилгээний албан хаагч нарт төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг хуулийн хэрэгжилтийн хугацаанд нь олгосон. Хэрэгжилт 100%		
8	10	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.8.22 дугаар 258 1.1 харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх.	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг сумын ЗДТГ-ын албан хаагч, ажилтан нарт танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулан авсан. Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, зөрчсөн албан хаагч эхний хагас жилээр байхгүй болно Хэрэгжилт 100%		
	11	1.2.Иргэдийг ялгаварлан гадуурахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж хугацаа хэтэрсэн өргөдөл гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ны өдөрт багтаан шийдвэрлэж хариуг өгөх, цаашид өргөдөл,	Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж иргэдийг ялгаварлан гадуурхахгүй, ижил тэгш, зөв шударга харьцаж чадахгүй байгаа талаар ЗДТГ-ын албан хаагч болон төрийн үйлчилгээний ажилтан нарын нэр дээр ямар нэг өргөдөл гомдол ирээгүй. Төрийн байгууллага иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Хэрэгжилт 100%		

		гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх.			
12		1.3.Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах.	Төрийн албан хаагч нарын ажлын байрны тодорхойлолтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан биелэлтийг тооцсон ажиллаж байна. Хэрэгжсэн 100%		
13		1.4.Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгуулагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.	Сумын Засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн гэрээгээр авч, ажиллуулж байна. Мөн хууль эрх зүйн ажилтан, ХАА-н мэргэжилтэн нарын сул орон тоог аймгийн төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгсөн. Хэрэгжилт 100%		
14		1.5.Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9-р сарын 1-ны өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг	Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгчийн албан тушаалд сонгон шалгаруулалт явагдан тусгай шалгалтанд тэнцсэн албан хаагчийг тамгын газрын даргаар томилсон . Хэрэгжилт 100%		

		томилох.			
	15	1.6.Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эхсүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул олон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримтлаж , төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилан ажиллуулахгүй байх.	Улс орон даяар коронавирус гарсантай холбогдуулан төрийн албан хаагч ажилтан нар сургалт, семинарт хамрагдаагүй. Төсөв албан байгууллага, гэрээт албан хаагч авч ажиллуулаагүй. Хууль дүрэм зөрчигдсөн тохиолдол гараагүй. Хэрэгжсэн 100%		
	16	1.7. Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох.	Төрийн албан хаагч нар томилолтоор ажиллах болон ажлын байрандаа архи согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдол гараагүй. Тогтоол зөрчсөн ажилтан гараагүй, арга хэмжээ авагдаагүй болно. хэрэгжилт 100%		

	17	1.8. Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тогтоон урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.	2020 онд харилцаа хандлага чиглэлээр ёс зүйн зөрчил гаргасан ажилтан байхгүй. Хэрэгжилт 100%		
	18	1.9.Төрийн байгууллагад ажилын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах.	Төсөвт албан байгууллагууд гарын хурууны хээ уншуулах болон камерын хяналтын системээр цагийг бүртгэдэг байсан боловч улс орон даяар Ковид19 өвчний тархалтаас шалтгаалан бүртгэх боломжгүй. Албан хаагч нарын цаг ашиглалтанд илүү хяналт тавин ажиллаж, 2-4 саруудад ажлын цагийг 2 цагаар богиносгон ажилласан. Хэрэгжилт 100%		
	20	1.10.Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээг авах.	Ажлын байранд доромжлолд өртсөн шахалт үзүүлсэн тохиолдол гараагүй. Албан хаагч ажилтан нараас үүнтэй холбоотой гомдол хүсэлт ирээгүй. Хэрэгжилт 100%		
9.	21.	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай 2009.05.14 дугаар 143 2. “Ил тод байдлыг илтгэх шалгуур”-ийг хангах арга	Албан байгууллага бүр эрхэм зорилт, зорилгоо мэдээллийн самбарт байрлуулан зарим албан байгууллагууд гэрлэн самбар байрлуулан иргэдэд хууль сурталчилан ажиллаж байна Төрийн албан байгууллагуудад ард иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх		

		<p>хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгох</p>	<p>ажилд анхааран ажиллаж ЗДТГазар дээр нэг цэгийн үйлчилгээг ажиллуулж байна. архив бичиг хэргийн ажилтан, нийгмийн даатгалын байцаагч, Газрын даамал, иргэний бүртгэлийн ажилтан, Татварын улсын байцаагч цаг уурын ажилтан нар, мөн Мал эмнэлэг үржлийн тасаг байцаагч нар нэг цэгээс үйл ажиллагаа явуулж байна. Иргэдээс үйлчилгээний талаас гомдол санал ирээгүй. Байгууллагын төсөв боловсруулах. Гүйцэтгэх тайлагнах үйл явц нээлттэй ил тод болсон байна Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уяалдуулан боловсруулсан.</p> <p>Хэрэгжилт 70%</p>		
10	22	<p>Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 2005.04.01 Дугаар 67</p> <p>1.б. Иргэдээс амаар, бичгээр болон цахим сүлжээ, радио телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр, түүнчлэн тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, шийдвэрлэлтийн явцыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг нийтэд зарлан сурталчлах зэрэг ажлыг дээрх журамд тусган хэрэгжүүлэх</p>	<p>Хэрэгжилт 100%</p>		

		арга хэмжээ авах			
11	23	Журам батлах тухай 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Дугаар 7 1.“Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам” –ыг хавсралт ёсоор баталсугай.	Төрийн албаны хууль шинэчлэгдэн гарсантай холбогдуулан түүнтэй уялдан гарч байгаа журмуудыг төрийн албан хаагч нарт сурталчлах ажлыг зохион байгуулж байна. ЗДТГ-ын 2 төрийн албан хаагч 2020 оны 3 дугаар сард тэтгэвэртээ гарч 1 удаагийн буцалтгүй тусламжийн мөнгөн урамшуулалыг мөнгө төгрөгөө авч тэтгэвэрт гарсан. Хэрэгжилт 100%		
12	24	ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ, ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ 2019 оны 12 дүгээр сарын 25-ны өдөр Дугаар 472 2. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтооход шаардагдах хөрөнгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төрийн албан хаагч нарынцалинг Засгийн газрын тогтоолын дагуу цалингийн сүлжээ хэмжээг шинэчлэн тогтоож 1-р сараас эхлэн олгосон. Хагас жилийн байдлаар төсөв мөнгө хэтэрсэн албан байгууллага байхгүй, батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 100%		
Хэсгийн дундаж 97,0					
Монгол улсын хууль					
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
13.	25	ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ НАРТ Монгол Улсын Засгийн газрын	Байгууллагын нийт ажилтны ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөө , хөдөлмөрийн гэрээнд албан хэрэг хөтлөлт,		

		2016 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуралдааны 7 дугаар тэмдэглэлд.	архивын ажлын талаар ажилтны хүлээх үүргийг тусгаж, гэрээг дүгнэхдээ харгалздаг байх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөл, нийт байгууллагын дарга эрхлэгч нарт зөвлөмж өгсөн.Төсөвт байгууллагуудын архивын өрөөг тохижуулан архивын баримтыг цэгцлэх ажлыг хийв. Төрийн захиргааны албан хаагч нарын ажлын байрны тодорхойлолт гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хөтлөлт архивын ажлын талаар ажилтан хүлээх үүрэгт тусгаж өгч дүгнэж байна. Хэрэгжилт 70%		
Хэсгийн дундаж 70					
Засгийн газрын албан даалгавар					
14	26	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017.10.26 дугаар 01 2.1.Албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах.	Монгол Улсын Засгийн газрын Сахилга ахариуцлага, дэг журмыг чангатгах тухай 01 дүгээр албан даалгаварыг Засаг даргын Тамгын газрын албан хаагч, албан байгууллагын дарга, эрхлэгч нарын шуурхай зөвлөгөөн дээр танилцуулан хувилж өгч албан байгууллага бүр төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажиллах талаар зөвлөгөө өгч ажиллаа. Төрийн албан хаагч нарыг ёс зүйтэй ажиллах талаар танилцуулан албан байгууллага бүр Ёс зүйн хороогоо шинэчлэн байгуулах арга зүйн заавар өгөв. Хэрэгжилт 70%		
	26	2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил худалдан авах ажлыг сумын төлөвлөгөөний дагуу Үнэлгээний хороо байгуулан иргэдэд ил тод, нээлттэй зохион байгуулж байна.3 удаа хяналт шалгалтыг явуулсан .		

		зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах.	Хэрэгжилт 100%		
	27	2.3.Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх.	Төсөвт байгууллагуудын албан хаагч нар төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүнд суртал гаргасан, хээл хахууль авсан тухай гомдол хүсэл иргэдээс ирүүлээгүй байна. Хэрэгжилт 100%		
	28	2.4.Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх.	Сумын Засаг даргын Тамгын газарт Шуурхай удирдлагын орон тооны бус зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллах журмыг танилцуулан ажиллав. Иргэдээс гомдол санал ирээгүй байна. Хэрэгжилт 100%		
	29	2.5.Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах.	Албан хаагч, ажилтан нар албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн гэрээг журмын дагуу боловсруулав. Хэрэгжилт 100%		
Хэсгийн дундаж 94%					
Сангийн яам					
15.	30	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2016.12.21 дугаар 193 : 1.	Орон нутгийн өмчид дахин үнэлгээ хийх ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилон өмч дахин үнэлэх ажлыг хийж байна. Засаг даргын Тамгын газрын ажилтан албан		

		<p>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>хаагч нартай өмч эзэмшлийн гэрээ байгуулан ажиллаж байна. Хагас жилийн байдлаар хөрөнгийг дахин бүртгэлд аваагүй. Албан байгууллагууд хагас жилийн тооллого бүртгэлийг явуулж байна.Сумын өмч хамгаалан Зөвлөлийн гишүүд албан байгууллагуудын акт, өмч хөрөнгийг зургийн хамт авч, сумын ИТХурлын тэргүүлэгчдийн хурлаар оруулж шийдвэрлэсэн.</p> <p>Хэрэгжилт 100%</p>		
Хэсгийн дундаж 100%					
Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам					
16	31	<p>Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай 2010.03.26 Дугаар 53</p> <p>2.Биеийн тамир, спортыг бүх нийтийн үйл хэрэг болгох зорилгоор дунд болон их дээд сургуулиудад биеийн тамир, спортыг сургалтын тэргүүлэх чиглэл болгож сурагч, оюутнуудыг спортоор хичээллэх таатай орчин нөхцлөөр хангах, спортын хамтлаг, клубын тогтолцоо нэвтрүүлж ажиллахыг ТББ, тамирчид, багш</p>	<p>Төрийн байгууллагуудын дунд КОВИД19 цар тахалтай холбогдуулан ямар нэгэн нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулагдаагүй.Сумын спорт заалны үйл ажиллагааг түр зогсоосон.</p> <p>Нийтийн биеийн тамирын асуудлыг хариуцан ажилтан шинээр томилон ажилд авсан .</p> <p>хэрэгжилт 70%</p>		

		дасгалжуулагчид, бизнесийн бүх байгууллага, нийт ард иргэдэд уриалсугай.			
17	32	<p>ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Дугаар 354</p> <p>1. “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.</p>	Улс орон даяар коронавирус өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын соёлын төвөөс сумын нэгдсэн группээр соёлын биет өвийг сурталчлах ажлыг зохион байгуулж түгээн дэлгэрүүлэх ажлыг хийж байна. Хэрэгжилт 70%		
18	33	<p>ТӨРӨӨС БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Дугаар 153</p> <p>3. “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, улс, орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхийг</p>	Тус сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд спорт заал барихаар тусгагдсан. Спорт заалны тендер аймгийн өмчийн газарт зарлагдан Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулдаг “Ган нэгдэл” ХХК шалгарч барилгын ажил 100%болсон. Үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэрэгжилт 70%		

		Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.			
Хэсгийн дундаж 70%					
Засгийн газрын тогтоол					
61	2	<p>Журам шинэчлэн батлах тухай</p> <p>/Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам/</p> <p>2021.04.20 Дугаар 61</p> <p>2. Шинэчлэн баталсан журмыг мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.</p>	5 дугаар сарын 01-нээс эхлэн шинэчлэн баталсан 61 дугаар тогтоолын дагуу Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг журмын дагуу мөрдөн ажиллаж байна.		
221	3	<p>Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай</p> <p>2021.07.28 Дугаар 221</p> <p>3. Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх,</p>	<p>Салбарын 2020-2021 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг Засгийн 221-р тогтоол Монгол улсын шадар сайд , ХААХҮ-ийн яамны сайдын хамтарсан албан даалгавар аймгийн сумын Засаг даргын захирамж зэрэг удирдамжийн баримт бичгүүд өвс тэжээл бэлтгэх даалгаварыг биелүүлэх малчдын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулахад чиглүүлж ажиллаа.</p> <p>Энэ онд тус сумын хөдөөгийн 4 багийн 175000 га бэлчээрийн талбайд тэмээ 252 адуу 17057 үхэр 8481 хонь 106918 ямаа 57355 нийт 190063 толгой мал буюу хонин</p>		

гамшгийн үед авах хариу арга хэмжээний талаар дор дурдсан ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

толгойд шилжүүлснээр 330158 толгой мал 480 хот айл 633 малчин өрх өвөлжиж хаваржина. Сумын Засаг даргын захирамжаар 2020-2021 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг томилж баг байгуулагуудыг хариуцуулж ажиллаа

Малчдын хүчээр бэлтгэх байгалийн хадлан өвс тэжээлийн төлөвлөгөөний биелэлт

№	Тэжээлийн төрөл	Бэлтгэвэл зохих тн-оор	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Байгалийн хадлан	1067	1000
2	Гар тэжээл	356	350
3	Давс хужир шүү	752	627

Сумын Аюулаас хамгаалах нөөцөд бэлтгэх өвс тэжээлийн төлөвлөгөө биелэлт

д\д	Тэжээлийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Өвс \тн\	150	155
2	Тэжээл \тн\	50	40

Сумын 2020-2021 оны МАА-н салбарын өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын дүнг Монгол Улсын Хүнс Хөдөө Аж Ахуйн сайдын 2016 оны А-71 тоот тушаалаар батлагдсан “Мал өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах шалгах дүгнэх заавар”-ын дагуу дүгнэлээ.

Зааварт заасан үнэлгээний үзүүлэлтээр 2020-2021 оны МАА-н салбарын өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын дүнг авч үзвэл:

- 1 Өвс тэжээлийн хангамж 101.3
- 2 Сумын Аюулгүй нөөц 91.5
- 3 Худгийн бэлэн байдал 95.4
- 4 Малын усан хангамж 88.9
- 5 Малын өрхийн хашаа саравчны хангамж 93.8

			6 Малчин өрхийн бэлтгэл хангалт 92.2 Сумын дүн 93.8		
235		2021 оны 8 дугаар сарын 11-ны өдөр Дугаар 235 Ургац хураалтын талаар авах зарим арга хэмжээний тухай	2021 оны “Хөдөө Аж Ахуй үйлдвэрлэлийг дэмжих зорилтот жилийн ажлын хүрээнд атаршсан 60 га талбайг дуудлага худалдаагаар эзэмшүүлж ашиглагдаагүй байсан 400 га талбайг эргэлтэнд оруулж Энэ онд 488 га-д малын тэжээл 5 га-д төмс 2 га-д хүнсний ногоо 186 м2 талбай бүхий хүлэмжинд нарийн ногоо тариалж 30 тн төмс 10.7 тн хүнсний ногоо хураан авсан. Хүйсийн голын 80 га талбайгаас 6.2 цн буюу 500 тн малын тэжээл Бадамжуннай хоршоо 6 га-аас 18 тн Жороогийн хөндий 400 га талбайгаас 500 тн тус бүр нийт 1030 тн ургац хураан авсан байна.		
32		2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр. Дугаар 32 Улсын аварга малчин өрх, Улсын хошой аварга малчин өрх, улсын аварга саальчин, тариаланч шалгаруулах тухай	2020 оны ажлын үр дүнгээр 2021 онд тус сумын 1-р багийн малчин Болоо овогтой Эрдэнэдалай Монгол улсын аварга малчнаар шалгарсан 2021 оны ажлын үзүүлэлтээр шалгаруулах малчин байхгүй байна.		
19	34	“МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2018 оны 1 дүгээр сарын 10-	Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын А/148 дугаар захирамжаар 04-р сарын 10 өдрөөс 10-р сарын 20-г хүртэл хугацаанд зохион байгуулан ажиллахаар		

		<p>ны өдөр Дугаар 12</p> <p>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>төлөвлөж байна. Одоогийн байдлаар нийт 67271 толгой малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулаад байна. Үүнд: ДХХ вакцинд 56042 толгой мал буюу 93,4%, дуут хавдарын вакцинд 50 үхэр буюу 6,3%, цусан халдварын вакцинд 1335 толгой мал буюу 89,0% шөвөг ярын вакцин 2873 богийн төл буюу 71,8% тус тус хамрагдсан байна. МЭҮНэгжийн вакцинжуулалтын явц хэрэгжилтэнд 2 удаа хяналт хийсэн Мал, амьтан болон тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээг адуу 3, үхэр 42, тэмээ 21 хонь 173, ямаа 25, нийт 9841 амьд малд, адууны мах 350кг, үхрийн мах 1650 кг, хонины мах 5241кг, Ямааны мах 287кг тэмээний 800 кг маханд мал эмнэлгийн гэрчилгээ олгож төв орон нутгыг эрүүл хүнсээр хангасан. Мал эмнэлгийн нэгдсэн системд 112 гэрчилгээ бичигдсэнээс орж ирсэн 22 гадагш гарсан 70 үүнээс отор нүүдлээр 44 гэрчилгээ бичигдсэнээс 19 орж ирсэн 25 гадагш гарсан, үйлдвэрлэл худалдаанд 18 гадагш гарсан, үзэсгэлэн худалдаанд 1 орж ирсэн 1 гарсан, үржилд 5 бичигдсэнээс 2 орж ирж 3 гарсан, хүнсэнд 43 гадагш гарсан гэрчилгээ бүртгэгдсэн байна. Хэрэгжилт 100%</p>		
20	35	<p>БЭЛЧЭЭР ХАМГААЛЛЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Дугаар 185</p> <p>4. 2019 оны бэлчээр хамгааллын арга хэмжээг нийтийг хамарсан ажил болгон зохион байгуулах, цаашид жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан,</p>	<p>Сумын Засаг даргын А\42 дугаар захирамжаар бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Засаг даргын захирамжийн хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу Үлийн цагаан оготно устгалын ажлыг Бор хошууны 1-р багийн Жаргалант, Фермийн тал, Борхошуу, Агуйт 2-р багийн нутаг Зэгэстэй, Майхан, Улаан дэлийн ар зэрэг газруудад нийт 8750 га талбайд устгалын ажлыг доор дурьдсан энгийн механик, биологийн аргуудаар бүлэг салааны зохион байгуулалттайгаар 4 салаа тус бүр 20 хүн нэг групп нийт 80 хүн, 11 машин ажилсан болно. Хөдөлмөр хамгаалалын чиглэлээр оготно устгалын ажилд ажиллагсад 180 ш</p>		

		<p>Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарлаж, мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>маск, 164 ш бээлий бүлэг тус бүрт саван, санетол олгосон. Устгалын ажлыг 2020 оны 05 сарын 10,11-ны өдрүүдэд зохион байгуулж 1-р салаа Засаг даргын тамгын газрын ХАА-н тасгийн мэргэжилтэн Д. Сономцэрэн ахлагчтай групп нь Өлзийт Бүрдний адаг, Жаргалантын энгэр, Эрэгцэг, Ботгын баруун зэрэг газруудад үлийн цөмлөх, конус тавих энгийн механик аргаар үлийн цагаан оготно устгалын ажлыг зохион байгууллаа . Тус сум нийт 196,0 мян га, нутаг дэвсгэртэй үүнээс 175 мянган га бэлчээрийн талбайтай үүнээс 90 хувь буюу 140 мянган га бэлчээрт үлийн цагаан оготно тархсан. Сумын Засаг даргын А\28 тоот захирамжаар бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан сумын Засаг даргын А\29 тоот захирамжаар Үлийн цагаан оготно устгах талбайд мал оруулахгүй бэлчээр чөлөөлөх асуудлаар устгал хийгдэх талбайгаас гадагш 5 км талбайд 35 хоногийн хугацаанд малчид мэдэгдэл өгч хорио цээр тогтоосон. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Борхошуу, Яргайт, Гуулин зэрэг 1,3,4-р нутгаар 04 дугаар сарын 07-ноос 11 хүртэл 5 хоногийн хугацаатай микробиологийн аргаар оготно устгах ажлыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллагтай хамтран нийтийг хамарсан ажлын хүрээнд 18 иргэн, малчдын хамт зохион байгуулсан. Бактержуулсан будаа цацахад аюулгүй ажиллагааны талаар, заавар зөвлөгөө өгч, маск, бээлий, нүдний шил, “ оп” цув, хор тайлах сүүг нормын дагуу өдөр, өдөрт нь олгож ажиллаа. Ажиллагчдын хүнсний хэрэгцээнд боорцог 15 уут ундаа 15 ш өгсөн</p> <p>1-р багийн нутаг дэвсгэрт Горхоны гол, Өлзийт бүрд, Борх, Сонор, Жороогийн адаг зэрэг газруудад 1,5 мянга га талбайд 6 иргэн 3-р багийн нутагт Баруун, Зүүн асга, Тойромууд, Ооно зэрэг газруудад 1 мянган га талбайд 6 иргэн, 4-р багийн нутагт Баахай, Баруун, цэгээний адаг, Гуулин, Тарвагат зэрэг газруудад 1 мянган</p>		
--	--	---	---	--	--

			<p>га талбайд 6 иргэн тус бүр ажилласан. Нийт 18 иргэн 3 портер машин, 3,5 мянган га-д “Шим” ХХКомпаний 8 тн бактержуулсан будаа цацаж устгал хийсэн.</p> <p>Засаг даргын орлогч, ХАА-н тасгийн мэргэжилтэн бэлчээр чөлөөлөхтэй холбогдуулан 1,3,4 багийн микробиологийн аргаар оготно устгах талбайд буусан малчин айл өрхүүдэд албан мэдэгдэл өгч ажилласан.</p> <p>Иргэд 6 хүн нэг баг болон ажилласан. Нэг багт 1 портер машин, 5 иргэн бактержуулсан будаа цацахаар ажилласан. Сумын байгаль орчны байцаагч өдөр тутам хяналт тавьж баг тус бүрт хяналтын цэг авч ажиллаж, микробиологийн аргаар үлийн цагаан оготно устгалын ажлыг 83,7 хувийн гүйцэтгэлтэй байцаагчийн дүгнэлт гаргасан.</p> <p>Хэрэгжилт 70%</p>		
21	36	<p>ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Дугаар 52</p> <p>3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Монгол улсын засгийн газраас батлагдсан “ Эрүүл хүнс – Эрүүл монгол хүн “ хөтөлбөрийг бүртгэлд авч сумын засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн төвтэй хамтран төлөвлөгөө боловсруулан хүнсний хэрэглээ, хугацаа чанарын талаар эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан, хүнс хариуцсан мэргэжилтэн хамтран сурталчилах ажлыг цахимаар зохион байгуулав. Хүнсний дэлгүүрийн худалдагч нарт хүнсний бүтээгдэхүүний хугацаа, чанарын тэмдэг, хадаглах горимын талаар гарын авлага тараав. Хүнсний худалдаа эрхлэдэг 3 дэлгүүрт хяналт шалгалт зохион байгуулан сургалт зохион байгуулав.</p> <p>Хэрэгжилт 70%</p>		
22	37	<p>Төлөвлөгөө батлах тухай /монгол мал хөтөлбөр /2010.9.1 дугаар 222 2. “Монгол мал” үндэсний</p>	<p>“Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийг хэрэгжүүлэхээр дагалдан гарч байгаа тогтоол шийдвэр, стандарт, дүрэм, журам, заавар, жагсаалтыг судлан сум орон нутгын ударлагад хүргэж, ард иргэдэд сурталчлах,</p>		

		<p>хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах үүднээс 4 янзийн боршур гарын авлага бэлтгэж, отор нүүдэл эргэх, малчдад тусламж дэмжлэг үзүүлэх, хөдөө багуудаар тойрох зэрэг ажлаар явж 140 малчин өрхөд сурталчилсан байна. энэ жилийн хувьд цар тахлын хүрээнд олон нийт цуглахыг хориглоод байгаа учир багийн ИНХурлыг товлон хуралдуулаагүй байна. малчдад бүлгийн уулзалтыг 3 удаа зохион байгуулж мэдээлэл сурталчилгаа хийсэн. Мөн Отор нүүдэл хийхэд хууль эрх зүйн зүгээс анхаарах асуудал, малын өвчин дэгдэлт судалгаа, малчдыг малын үзлэг шинжилгээнд тогтмол хамруулж байх нь альваа эрсдэлээс урьдчилан сэргийлж болох талаар ганцаарчилсан зөвлөгөөг 64 малчинд өгсөн байна. “Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 дугаар шатны /2017-2021 онд/ ажлыг төлөвлөгөө гарган сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувийн хэрэгжилттэй байгаа. 2019 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэр зааж төсөвт хөрөнгө тусгаагүй. Урд жилүүдэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 1,9 сая төгрөг тусгагдсан байна. Энэ жил хөрөнгө тусгаагүй. Сумын мал эмнэлэгийн улсын байцаагчийн ширээ, сандал , техник хэрэгсэлээр хангагдсан.</p> <p style="text-align: center;">Хэрэгжилт 70%</p>		
23	38	<p>Төлөвлөгөө батлах тухай /төрөөс малчдын талаар баримтлах бодлого/ 2009.7.8 дугаар 208 2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж</p>	<p>Бог малын үржлийн хэлтүүлэгчийн 88,6% буюу 748 хээлтүүлэгчийг 4 багт 4 малчин дээр ялган суурилж МЭ-ийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж эрүүл мэндийн үзлэг хийж ээмэгжүүлсэн. 268 хуц ухнаас цусны шинжилгээ авч аймгийн МЭ-ийн лаброторид шинжлүүлсэн. Өвчний шинж тэмдэг илрээгүй. Малчид МЭ-ийн байгууллагад нийт 15 дуудлага ирүүлсэн байна. Дуудлага бүрт хүрч үйлчилсэн. Үүнээс сумын МЭҮТ 2 удаагийн дуудлаганд явж үйлчилсэн. Эмнэлэгийн тусламж үйлчилгээ урьдчилан сэргийлэх үзлэгт 574 малчин иргэн хамрагдсан. Дуудлагаар давхардсан тоогоор 120 иргэнд</p>		

		ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	түргэн тусламж үзүүлсэн. Эрүүл мэндийн сурталчилгааг 4 багийн төв дээр зохион байгуулсан ба сургалт сурталчилгаанд нийт 460 гаруй малчид хамрагдсан Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 50%-ийн биелэлттэй. Орон нутгийн төсөвт төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд нэр зааж хөрөнгө тусгагдаагүй. Сумын ялган суурлан ялгасан хуц ухны улгаалга, т тарилга туулгалтын мөнгө төгрөгийг тамгын газраас хариуцан төлсөн. Хэрэгжилт 70%		
24	39	Арьс ширний урамшуулал олгох тухай . 2013.11.24 дугаар 394	Засгийн газрын тогтоолын дагуу 2019 оны эцэст 478 өрх 13,5 мянган ширхэг арьс шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушааж урамшуулалд хамрагдсан. Арьс ширний падааныг иргэдээс хүлээн авч шивэх ажлыг ХАА-н тасгийн мэргэжилтэн нар хийсэн байна. Хэрэгжилт 100%		
Хэсгийн дундаж 82%					
Хууль зүй, дотоод хэргийн яам					
Засгийн газрын тогтоол					
25	40	Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2017.2.1 дугаар 46 3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж	Худалдаа үйлчилгээ эрхэлдэг сумын төвийн 2 дэлгүүр, 1 гуанз, Бор хошууны багт үйл ажиллагаа явуулдаг 2 дэлгүүр 3 гуанзны үйл ажиллагаанд хүнс хариуцсан мэргэжилтэн, татварын байцаагч, цагдаагийн төлөөлөгч нарын бүрэлдэхүүнтэй 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулан дүн мэдээг танилцуулан аж ахуйн нэгж, дэлгүүрүүдэд зөвлөн туслах ажиллагааг явуулсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 4,3 сая төгрөгөөр сумын төвийн урд уулын орой дээр өдөр шөнөгүй 360 градусын эргэлттэй камерыг суурилуулан дэлгэц болон		

		ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд тус тус үүрэг болгосугай.	холбогдох тоног төхөөрөмжийг цагдаагийн албаны байранд Цагдаагийн ажилтаны хяналтанд суурилуулан өгсөн. Эргэн тойрон 5 км-ын бичлэг хийх хүчин чадалтай камер тавьсан.Одоогоор засварлах ажлыг хийж камерын таталтын нэмэгдүүлэхээр шинэчлэж байна. Хэрэгжилт 70%		
26	41	Журам батлах тухай 2017.5.17 дугаар 144 2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2020 оны хаврын 1-р ээлжийн цэрэг татлагын ажлыг 4-р сарын 19-ны өдөр зохион байгуулан нийт 114 залуучууд орохоос 96 хувь хамрагдсан. Энэ удаа оюутан залуучуудын хамралт илүү сайн, эрүүлжилт урд оноос 25 хувиар буурсан үзүүлэлт гарч 5 залуу цэрэгт явсан., Өмнөговь аймагт 5 залуу цэргийн алба хаахаар мордсон. Хэрэгжсэн 100%		
27	42	Журам шинэчлэн батлах тухай 2017.3.15 дугаар 89 2. Энэхүү журмыг үндэслэн эрхэлсэн самбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинэжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон	Монгол улсын Засгийн газрын 89 дүгээр тогтоолыг албан байгууллагын дарга, эрхлэгч, албан хаагч нарт танилцуулан тогтоол шийдвэр хөтөлбөр болон хяналт шинжилгээ тогтоолын биелэлтийг тооцон ажиллаж байна. Хэрэгжилт 100%		

		аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.			
28	43	<p>ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Дугаар 163</p> <p>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд, хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх замаар хэрэгжүүлэхийг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Тус сумын цагдаагийн ажилтан нар 7 хоног бүрийн 4 өдөр сумын хилийг дайран өнгөрдөг Улаанбаатар-Өвөрхангайн засмал зам дээр эргүүлд гарч энэ оны 6 сарын байдлаар 1,5,сая төгрөгийн зөрчил илэрүүлэн ажилласан байна..</p> <p>Жолооч нарын архи согтууруулах ундаа хэрэглэхээс урьдчилан сэргийлж гарын авлага, тараах материал олгосон. Сумын хэмжээнд гэмт хэрэг гаралтыг багасгах зорилгоор сумын төвийн урд уулын оройд 360° эргэлттэй камерыг байрлуулан Цагдаагийн газарт тоног төхөөрөмжийг суурилуулан ажиллаж байна. Жолооч нарын дунд “Аюулгүй бүс”, “Каск” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Хэрэгжилт 70%</p>		
Хэсгийн дундаж 85%					
Эрүүл мэндийн яам					
Засгийн газрын тогтоол					
29	44	<p>АМЬСГАЛЫН ЗАМЫН ЦОЧМОГ ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ</p>	Ханиад томуу ихэсч байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн төвөөс томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБС-ийн бага ангийн хүүхдүүд, СӨБ-ийн хүүхдүүд, эцэг эхийн хамт мэдээлэл сурталчилгаа зохион байгууллаа.. Мөн Ам хамар хоолойд утлага хийх зөвлөмжийг айл болгонд тараасан:		

		<p>2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр</p> <p>Дугаар 31</p> <p>1. Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчин улсын хэмжээнд нэмэгдэж байгаатай холбогдуулан өрхийн эрүүл мэндийн төвийг 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд Бямба гараг бүрт ажиллуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>Томуугийн А/Н1И1/ вирусын халдварын үед амьсгалын замын эрхтэнг зонхилж гэмтээдэг учир урьдчилан сэргийлэх зорилгоор ам, хамар, хоолойд утлага хийх аргачлалыг хэвлэн тарааж өгөв. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс өндөр настан бага насны хүүхдүүдийг вакцинжүүлэх арга хэмжээ авч ажиллав. ЕБС-ийн сурагчдад Цэцэрлэгийн хүүхдүүдийн ханиад томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс дулаан хувцаслах, аарц, чацаргана тогтмол хэрэглэж хэвших талаар арга зүйн заавар зөвлөгөөг Эрүүл мэндийн төвөөс өгч ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт 70%</p>		
	45	<p>2. 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд 5 хүртэлх насны хүүхдээ 3-5 хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчид цалинтай чөлөө олгохыг ажил олгогч нарт даалгасугай.</p>	<p>Коронавирусын өвчин тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБСургууль цэцэрлэгийн соёлын төвийн 0-12 насны хүүхэдтэй эцэг эхүүдийг 4 цагийн хугацаатай ажиллуулсан.Зарим сар бүтэн ажиллуулаагүй сумын хэмжээнд 20 эх хамрагдсан .</p> <p>Хэрэгжилт 70%</p>		
30	46	<p>Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги батлах тухай 2015.8.31 дугаар 3533.Үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын</p>	<p>Давсны зохистой хэрэглээний талаар нийт Сумын төвийн ард иргэдэд гал тогоо бүхий байгуулагуудын тогооч сурталчилгаа зохион байгууллаа. Голзорилго нь нэн түрүүнд давсны хэрэглээг бууруулах, давсыг их хэтрүүлж хэрэглэсэнээр ямар хор хөнөөл болдог талаар сугалтыг зохион байгуулан Мөн гарын авлага тарааж иргэдийн мэдлэгийг</p>		

		болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	дээшлүүлсэн. Давсны хэрэглээг бууруулахад нэлээд ач тус мэдлэг мэдээллээр хангахад анхаарч ажилласан болно. Мөн “Айл өрх бүрт хэвшүүлэх 10 дадал”-ыг сэргээж айл өрх бүрд шинээр хэвлэж өгч хэвшүүлэн ажиллахыг уриалсан. Төрийн албан хаагчдын таргалалтын 2-р зэргийн иргэдийн давсны хэрэглээг 3 гр хүртэл бууруулах зөвлөн хэрэгжүүлэн ажиллав. Хэрэгжилт 100%		
Хэсгийн дундаж 80					
Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам					
199	1	Журам шинэчлэн баталж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай /Эх эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журам/ 2021.07.07 Дугаар 199 1.“Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	Олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журмын дагуу 1 эхэд 1260000 төгрөг, тэтгэмж олгон шинээр 1 эх хамрагдах хүсэлт гаргасан. Жирэмсэн эхийн тэтгэмжинд 38 эх шинээр хамрагдан 53 эхэд 8702522 төгрөг, цалинтай эхийн тэтгэмжинд 36 иргэн үүнээс эцэг 6 шинээр хамрагдан 140 эхэд 53305053 төгрөгийн тэтгэмж олгосон.		
А/103	2	Журам шинэчлэн батлах тухай /Хүнсний эрхийн бичиг олгох журам/ 2021.06.25 Дугаар А/103 2. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд	2021 онд нийт 28 өрхийн 140 иргэнд 19944000 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлээд байна. " Хүнсний эрхийн бичиг олгох" журмыг Хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан журмын дагуу 8 өрхийн 35 иргэн мөн ажил хөдөлмөр эрхэлж байгаа 8 иргэн нийт 43 иргэн		

		хүнсний эрхийн бичиг олгох босго оноог орон нутагт 310.0, нийслэлд 292.5 ба түүнээс доош байгаа өрхийн гишүүн-иргэнд сард олгох хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг нэг хүүхдэд 8000 /найман мянган/ төгрөгөөр, насанд хүрсэн нэг гишүүнд 16000 /арван зургаан мянган/ төгрөгөөр тус тус тогтоосугай	буюу нийт өрхийн 28,5 %, иргэний 30,7% нь хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түдгэлзээд байна.		
31	47	Журам батлах тухай 2017.1.25 Дугаар 31 2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын дагуу ахмад настанд насны хишиг олгох ажлыг 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт үүрэг болгосугай.	Нийгмийн халамжийн хуулийн дагуу 311 ахмадад 311,0 Цагаан сараар хүндэтгэл үзүүлэн одонтой 265 ээжид 35700,0 мянган төгрөгийг олгосон байна. Хэрэгжилт 100%		
32	48	ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Дугаар 159 4. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил	Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Иргэдийг ажлын байраар хангах зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг хангах зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3 иргэнд бизнесийн жижиг зээл 9000,0 мянган төгрөг, Нийгмийн халамжийн сангаас 31 өрхийн 150 иргэнд сар бүр 2325,0		

		<p>бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Түр ажлын байраар 70 иргэн Оготно устгахад, сумын төвийн чулуу түүж, цас арилгахад 24 иргэн хамрагдан ажилласан байна. Ахмад настны зөвлөх үйлчилгээнд 2 иргэн төслөө өгөөд байна. Хэрэгжилт 70%</p>		
		Хэсгийн дундаж 85%			
Барилга хот байгуулалтын яам					
220	2	<p>Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг батлах тухай 2021.07.28 Дугаар 220</p> <p>2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>2019-2021 онд 3-р багийн иргэн С.Гонгор, Ц.Ёндон нар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж дуусгасан. 2020-2022 онд 1-р багийн иргэн Намжилдорж, 4-р багийн иргэн Лүүжин нар, 2021-2023 онд 2-р багийн иргэн Г.Шаарав, 4-р багийн иргэн М.Пүрэвжамц, М.Гантөмөр нар дүйцүүлэх албыг хааж байна. Дүйцүүлэх алба хааж байгаа иргэд аймагт цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалтад 14 хоног, аймгийн бүтээн байгуулалтын ажилд 21 хоног, Тарны гүүрэн дээр Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлаар ажиллаж байгаа хүмүүстэй 14 хоног, Хархорин суманд 15 хоног тус тус ажилласан</p>		
262		2021 оны 8 дугаар сарын 25-ны	Сумын төвд 7 иргэн 0,54га Сумын засаг		

		<p>өдөр Дугаар 262 Иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай</p>	<p>даргын 2021 оны А/121 тоот захирамжаар 2 иргэнд 0,19га газрыг, Улсын чанартай авто зам дагуу 7 иргэнд 0.49 га газар өмчлүүлэхээр төлөвлөснөөс 2021 оны А/121 тоот захирамжаар 2 иргэнд 0,14 га газрыг өмчлүүлсэн.</p>		
33	49	<p>ИРГЭНД 2019 ОНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТЫГ ТОГТООХ ТУХАЙ 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Дугаар 119</p> <p>1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг хавсралт ёсоор баталсугай.</p>	<p>Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар өвөлжөө хаваржааны зориулалтаар 6 иргэнд эзэмших эрх олгож газрыг эзэмшүүлэн лэнд менежер программд оруулж мэдээллийн санд бүртгэсэн 3 иргэнд газар өмчлөх эрхийг олгосон болно. Хэрэгжилт 100%</p>	70	
34	50	<p>2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 182 дугаар тогтоол Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл /бүс/ суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай Нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийг түүний тогтоосон суурь үнэлгээний 0.03 хувь, үр тариа, төмс хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн зориулалттай нэг га газрын төлбөрийг</p>	<p>Засгийн газрын 182 дугаар тогтоолын дагуу Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 09/01 дугаар тогтоол гаргуулан газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын газрын төлбөр ногдуулалтыг ГТМ-4 маягтаар гаргаж төлбөрийг төвлөрүүлэн ажиллаж байна. Төлбөр хураамж 52% байна. Хэрэгжилт70</p>		

		түүний тогтоосон суурь үнэлгээний 0.03 хувь, нэг га хадлангийн газрын төлбөрийг түүний суурь үнэлгээний 0.01 хувь, хот, тосгон, бусад суурины нэг га газрын төлбөрийн хэмжээг түүний суурь үнэлгээний 0.1-1.0 хувь, чөлөөт бүсийн 1 га газрын төлбөрийг түүний суурь үнэлгээний 1.0 хувь байхаар тус тус тогтоосугай.			
315		2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Дугаар 315 Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай	Тус суманд 25 Аж ахуйн нэгж, 8 хувиараа аж ахуйн эрхлэгч иргэн, Аж Ахуйн нэгжийн Улсын тооллогод цахимаар бүрэн хамрагдсан.		
Хэсгийн дундаж 85%					
Жилийн эцсийн хэрэгжилт 87,6					

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:.....Л.ГАНТУЛГА

БИЕЛЭЛТИЙГ ТООЦСОН:ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖИЛТАН:.....Н.ГАНБААТАР